



ДУНДГОВЬ АЙМАГ  
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/56

Аргатай

Шүлхийн өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтын арга хэмжээг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Засгийн газрын ХХААХҮ-ийн сайдын 2023 оны А/02 дугаар тушаал, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн А/87 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/588 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Малчид мал бүхий иргэдэд вакцинжуулалтын мэдээлэл хүргэн, нийт үхэр сүргийг дархлаажуулалтад бүрэн хамруулах арга хэмжээг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан стандарт ажиллагааны дагуу 2023 оны 10 дүгээр сарын 15-ны өдрөөс 14 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Мал амьтны гоц халдварт “Шүлхий” өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг чанартай зохион байгуулж, гүйцэтгэлийн баримт бичгийг цаг хугацаанд нь Мал эмнэлгийн тасагт хүлээлгэн өгөхийг Боржигон-Эрдэнэ ХХК-ний малын эмч (Ц.Даариймаа), Бор дарс ХХК-ний малын эмч (Ц.Дуйнхаржав), Энх-Эрдэнэт сүрэг мал эмнэлгийн эмч (П.Энхбаатар) нарт үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтын арга хэмжээг малчин болон мал бүхий иргэдэд зарлан мэдээллэж, мал сүргийг бүрэн хамруулахыг 1 дүгээр багийн засаг дарга (М.Мөнгөнхуяг), 2 дугаар багийн засаг дарга (Э.Дашдамба), 3 дугаар багийн засаг дарга (Б.Пүрэвбаяр) нарт үүрэг болгосугай.

4. Вакциныг цаг хугацаанд нь татан авчирч мал эмнэлгүүдэд хуваарилан дархлаажуулалтыг явц гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Ц.Батбилэг)-г үүрэг болгосугай

ДАРГА



О.УУГАНБААТАР

487301100